



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/193

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/16 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт (100 га, Бугат, Бүрэгхангай, Сэлэнгэ, Орхон, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр)-ын 2 дугаар багцын 114,892,500 (нэг зуун арван дөрвөн сая найман зуун ерэн хоёр мянга таван зуу) төгрөг, 3 дугаар багцын 158,897,500 (нэг зуун тавин найман мянга найман зуун ерэн долоон мянга таван зуу) төгрөгийн ажлын гүйцэтгэгчээр "Хөвөнтөн ой" ХХК-ийг сонгож гэрээ байгуулах эрхийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, журмын хүрээнд гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Хөвөнтөн ой" ХХК (Ч.Оюун)-д даалгасугай.

4. Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зардлын "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт (100 га, Бугат, Бүрэгхангай, Сэлэнгэ, Орхон, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр) төсөл арга хэмжээнээс 273,379,000 (хоёр зуун далан гурван сая гурван зуун далан есөн мянга) төгрөгөөр санхүүжүүлэхийг нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

60973010149